

МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Ангилалтын код: 13.020

Байгаль орчин. Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын ангилал	MNS 5915 : 2008
Environment Classification of land destroyed due to mining activities	MNS 17.5.1.18:1983-ын оронд

Стандартчилал, Хэмжилзүйн Үндэсний Зөвлөлийн 2008 оны 11 дүгээр сарын 27-ний өдрийн 61 дүгээр тогтоолоор батлав.

Энэхүү стандарт нь 2009 оны 02 дугаар сарын 01-ны өдрөөс эхлэн хүчинтэй.

Энэхүү стандартын шаардлагыг заавал мөрдөнө.

1 Зорилго

Энэ стандартын зорилго нь эвдэрсэн газрыг ангилах, түүнийг нөхөн сэргээсний дараа ашиглах чиглэлийг тогтооход оршино.

2 Хамрах хүрээ

Энэ стандарт нь уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрыг нөхөн сэргээх, нөхөн сэргээлтийн төсөл боловсруулж, хэрэгжүүлэхэд хамаарна.

3 Норматив ишлэл

Энэхүү стандартад дараах иш татсан стандарт, баримт бичгүүдийг хэрэглэв. Он заасан ишлэлийн хувьд зөвхөн иш татсан хэвлэлийг хэрэглэнэ. Үүнд:

- ISO 19258:2005 Хөрсний чанар– Хөрс хамгаалал ба бохирдсон газруудын дэвсгэр үзүүлэлтүүдийг тодорхойлох удирдамж;
- ГОСТ 17.5.1.02:1985, Байгаль хамгаалал. Хөрс. Эвдэрсэн газрын ангилал;
- MNS 5914:2008 Байгаль орчин. Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Нэр томъёо, тодорхойлолт

4 Техникийн ерөнхий шаардлага

Ил уурхайгаар ашиглах явцад эвдэрсэн газрын ангилалыг 1-р хүснэгт, далд уурхайгаар ашиглах явцад гадаргууд гарах эвдрэлийг 2-р хүснэгт, ил, далд уурхайгаар ашиглах явцад эвдэрсэн газрыг ашиглах чиглэлийг 3, 4-р хүснэгтийн дагуу ангилна.

1-р хүснэгт - Ил уурхайгаар ашиглах явцад эвдэрсэн газрын ангилал

Эвдэрсэн газрын бүлэг	Эвдэрсэн газрын гадаргуугийн хэлбэршилтийн тодорхойлолт	Гадаргууг хэлбэршүүлэх хүчин зүйл	Гадаргуугийн зонхилох элемент	Гадаргуугийн үүслийн тодорхойлолт	
				Жинхэнэ гадаргуутай харьцах гүн буюу өндөр, м	Доголын налуугийн өнцөг, град
Ил уурхайн ухаш	Дэнжилсэн Их гүнтэй	Налуу (8-30 ⁰) буюу эгц (30 ⁰ –аас дээш) уналтай гүний тогтоцтой ашигт малтмалын биетийн олборлолт, гадаад овоолго бүхий ашиглалт	Ил уурхайн хажууг дагасан доголдууд, уланд ёроол, доголдуудад налуу хажуу	100-аас илүү	45-аас дээш
	Гүн	Гүний тогтоцтой налуу ба эгц уналтай ашигт малтмалын биетийн олборлолт, гадаад овоолго бүхий ашиглалт	Ил уурхайн хажууг дагаад доголдууд, уланд ёроол, доголдуудад налуу хажуу	30-100	45-аас дээш
	Дунд зэрэг гүн	Хэвтээ ба хэвгий (8-10 ⁰ хүртэл) уналтай дунд зэрэг зузаантай (30 м хүртэл) биетийг 2-3 доголоор олборлох, хөрс хуулалтгүй, маш бага хөрс хуулалттай ашиглалт	ёроолын талбай, доголдууд	15-30	45-аас дээш
	Хонхор хэлбэрийн дунд зэрэг гүн	Хэвтээ болон хэвгийн уналтай талбайн хэлбэрийн дунд зэрэг зузаантай (30м хүртэл) биетийг нэг доголоор олборлох, хөрс хуулалтгүй буюу маш бага хөрстэй ашиглалт	Ёроолын талбай, хажуу	15-30	45-аас дээш
	Гүн бус	Хэвтээ ба хэвгийн тэгш уналтай талбайн хэлбэрийн, бага зузаантай (5-10 м хүртэл) биетийг нэг доголоор олборлох хөрс хуулалтгүй буюу маш бага хөрс хуулалттай ашиглалт	Ёроолын талбай, хажуу	5-15	30-аас дээш
	Хонхорхой хэлбэрийн	Хэвтээ ба хэвгий уналтай маш бага зузаантай (5-10 м хүртэл) биетийг олборлох хөрс хуулалтгүй ашиглалт	Ёроолын талбай, хажуу	1,5-5	45-аас дээш
	Уул дэнжилсэн гүний	Налуу ба эгц уналтай янз бүрийн зузаан бүхий уул гүний тогтоцтой биетийн олборлолт, хөрсийг гадаад овоолгод хураах ашиглалт	Ил уурхайн хажууг дагаад доголдууд, ёроолын талбай	Уулын хэсэг 15-аас дээш, гүний хэсэг 15-аас дээш	45-аас дээш

1-р хүснэгтийн үргэжлэл

	Уулын дэнжилсэн	Налуу ба эгц уналтай янз бүрийн зузаантай гүний тогтоцтой биетийг хэд хэдэн доголоор олборлох ашиглалт	доголууд	30-с дээш	45-аас дээш
Дотоод овоолго	Орчны гадаргуутай ойролцоо өндөртэй хавтгай орой бүхий	30 м хүртэл зузаан хөрс бүхий гүний тогтоцтой хэвгий уналтай бага зузаантай (20 м хүртэл) ашигт малтмал олборлох үеийн тээвэртэй ашиглалт дахь овоолго үүсгэлт	Хавтгай орой	0-5	25-35
	Дэнжилсэн хавтгай орой бүхий	Гүний тогтоцтой хэвгий уналтай ашигт малтмалын биетийг тээвэртэй ашиглалтын системээр ашиглахад хоёроос дээш үе бүхий овоолго үүсгэлт. Хөрсний зузаан 40 м-ээс дээш	Овоолгын нуруунууд	Нурууны хэсгийн өндөр 15 хүртэл	30-45
Гадаад овоолго	Дунд зэрэг өндөртэй хавтгай орой бүхий	Тээвэртэй ашиглалт бүхий уурхайн нэг үет овоолго ба гидро овоолго	Хавтгай орой, хажуу	15-30	25-30
	Дунд зэрэг өндөртэй, хавтгай орой бүхий дэнжилсэн	Тээвэртэй ашиглалтын систем бүхий уурхайн хоёр үетэй овоолго	Хавтгай орой, хажуу дэвсгэг	30-50	45 хүртэл
	Өндөр ба маш өндөр	Тээвэртэй ашиглалтын систем бүхий уурхайн олон үетэй овоолго	Хавтгай орой, хажуу дэвсгүүд	50-100	45 хүртэл
	Нуруулдсан (дэл)	Тээвэргүй ашиглалтын систем бүхий ил уурхайн захын овоолго	Нуруулдсан овоолгын систем, хажуу	30 хүртэл	45 хүртэл
	Дэнжилсэн хажуу бүхий нуруулдсан (дэл)	Олон үет овоолгын дээд үед драглайн буюу овоолго үүсгэгчээр үүсгэсэн овоолго	Дээд хэсэгтээ нуруулдсан дэлүүдийн систем, хажууд дэнжилсэн	30-100	45 хүртэл

2-р хүснэгт - Далд уурхайгаар ашиглах явцад эвдэрсэн газрын ангилал

Эвдэрсэн газрын бүлэг	Эвдэрсэн газрын гадаргуугийн хэлбэрийн тодорхойлолт	Гадаргууг хэлбэршүүлэх хүчин зүйл	Гадаргуугийн зонхилох элемент	Гадаргуугийн үүслийн тодорхойлолт	
				Жинхэнэ гадаргуутай харьцах гүн буюу өндөр, м	Доголын хажуугийн өнцөг, град
Цөмрөлт	дугуй	Шток хэлбэрийн эгц уналтай (45° –аас дээш) тогтоцтой биетийн таазны нураалттай олборлох ашиглалт	хажуу	5-15	45-аас дээш
	Суврага хэлбэрийн	Дунд ба их зузаантай (15 м-ээс дээш) эгц уналтай давхарга хэлбэрийн тогтоцтой биетийн ашиглалт	хажуу	5-15	30-аас дээш
	Хонхор	Хэвтээ ба хэвгий уналтай (27° –аас хүртэл) давхарга хэлбэрийн тогтоцтой биетийн ашиглалт	Хажуу, ёроол	1,5-5	5-15
	Дэнжилсэн	Налуу гадаргуу бүхий талбай дахь хэвгийн уналтай давхарга хэлбэрийн тогтоцтой биетийн ашиглалт	Дэвцгүүд	Тодорхойлохгүй	30-аас дээш
хотойлт	Хонхорхой	Хэвтээ ба долгион хэлбэрийн тогтоцтой биетийн, хэвгий уналтай давхаргын таазны нураалттай ашиглалт	Ёроол, хажуу	1,5- хүртэл	5-15
Овоолго	Хавтгай хэлбэрийн	Дан үетэй овоолго дүүргэлт	Дээд тавцан, хажуу	30 хүртэл	45 хүртэл
	Дэнжилсэн хавтгай хэлбэрийн дунд зэрэг ба өндөрдүү	чулуулгийн хоёр үетэй овоолго дүүргэлт	Дээд тавцан, дэнжилсэн хажуу	15-30	45 хүртэл
	Өндөр	Олон үетэй овоолго	Дээд тавцан дэнжилсэн хажуу	30-100	45 хүртэл
	Нуруулдсан (дэл хэлбэрийн)	Өлгүүр дүүжин замын тээврээс асгалт хийсэн овоолго	Нуруунуудын систем, хажуу	15 хүртэл	45 хүртэл
	Конусан	Скиф буюу хөмөрдөг тэргэнцрээс асгалт хийсэн овоолго	хажуу	30-аас дээш	30-45

**3-р хүснэгт - Ил уурхайгаар ашиглах явцад эвдэрсэн газрыг
нөхөн сэргээж аж ахуйн эргэлтэнд
оруулах чиглэл (ангилал)**

Нөхөн сэргээх чиглэл		Нөхөн сэргээсэн газрыг ашиглах хэлбэр
Хөдөө аж ахуйн чиглэл		Бэлчээр, хадлан, тариалангийн талбай
Ойн аж ахуйн		Аж ахуйн зориулалттай ба хамгаалалтын зурвас үүсгэх ойжуулалт, үрсэлгээний талбай
Усны аж ахуйн		Ахуйн ба үйлдвэрлэлийн ус хангамж
Тусгай зориулалтаар	Амралт спортын	Хүрээлэн, цэцэрлэгт хүрээлэн, эрүүлжүүлэх усан сан, агнуурын эдэлбэр, жуулчны бааз, спортын байгууламж
	Байгаль хамгаалах, эрүүл ахуйн	Байгаль хамгаалах зориулалттай хэсгүүд: Хөрсний эвдрэлээс сэргийлэх ойжуулсан; зүлэгжүүлсэн; техник хэрэгслээр бэхжүүлсэн, нөөшилсөн хэсэг, өөрөө нөхөн сэргээгдэж ургамалжих хэсэг
	Барилга байгууламжийн	Үйлдвэрлэл, иргэний ба бусад байгууламж ба үйлдвэрлэлийн хаягдал (чулуулаг, барилгын хог хаягдал, баяжуулалтын хаягдал гэх мэт) хураах байгууламж

**4-р хүснэгт - Далд уурхайгаар ашиглах явцад эвдэрсэн газрыг
нөхөн сэргээж аж ахуйн эргэлтэнд оруулах чиглэл /ангилал/**

Нөхөн сэргээх чиглэл	Нөхөн сэргээх газрыг ашиглах хэлбэр
Газрын доорх агуулах	Гүний усан сан, нөөцийн материал хадгалах, хорт бодис, хаягдал булшлах
Эмчилгээний камер	Ионжсон агаар бүхий эмчилгээний камер байгуулах
Сургалтын полигон	Мэргэжлийн сургалт явуулах, үзүүлэх сургууль явуулах, сургалтын музей байгуулах, туршилт судалгааны лаборатори байгуулах
Битүүмжилж хаах	Төмөр бетон хийцээр битүүмжлэн хаана.

ТӨГСӨВ.